



НИЙСЛЭЛИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГАЗАР ОНӨААТҮГ ДАРГЫН ТУШААЛ

2023 оны 05 сарын 19 өдөр

Дугаар 2/76

Улаанбаатар хот

Үнэлгээний хороо байгуулж,
тушаал хүчингүй болгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1, 47 дугаар зүйл, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.10, Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын 2023 оны А/612 дугаар захирамж, “Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар” ОНӨААТҮГ-ын дүрмийн 6 дугаар зүйлийн 6.11 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын 2023 оны 09 дүгээр сарын 08-ны өдрийн А/612 дугаар захирамжийн хавсралтаар батлагдсан төсөл, арга хэмжээний жагсаалтын 2 дугаарт заасан ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах Үнэлгээний хорооны бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

2. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, холбогдох журам, шийдвэрийг мөрдөн ажиллаж, үр дүнг тайлагнахыг Үнэлгээний хорооны дарга (С.Баасансүрэн)-д даалгасугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Ерөнхий инженер (Т.Оргил-Эрдэнэ)-т даалгасугай.

4. Төсөл арга хэмжээний ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулалттай холбоотой бүх баримт бичгээр архивын нэгж бүрдүүлэн холбогдох албан тушаалтанд хүлээлгэн өгөхийг Үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга (Ж.Солонго)-д үүрэг болгосугай.

5. Энэ тушаал гарснаар Газрын даргын 2023 оны 08 дугаар сарын 28-ны өдрийн А/71 дүгээр тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА

Б.МОНХБАТ





Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газрын
даргын 2023 оны 09 дугээр сарын 19-ний
өдрийн 29/96 дугаар тушаалын хавсралт

ҮНЭЛГЭЭНИЙ ХОРООНЫ БҮРЭЛДЭХҮҮН

ДАРГА:

С.БААСАНСҮРЭН

(НХОГ-ын Барилга захиалагчийн
хэлтсийн Бүсийн Ахлах инженер)

ГИШҮҮД:

У.НАМУУН

(Нийслэлийн Засаг даргын
Тамгын газрын Хөгжлийн бодлого
төлөвлөлтийн хэлтсийн Хөрөнгө
оруулалтын гэрээний
баталгаажуулалт, бүртгэл хяналт
хариуцсан мэргэжилтэн)

М.ЭРДЭНЭБАЯР

(НХОГ-ын Зураг төслийн хэлтсийн
Газрын асуудал хариуцсан
мэргэжилтэн)

Г.ШООВДОР

(Баянгол дүүргийн 15
дугаар хорооны иргэн)

НАРИЙН БИЧГИЙН

ДАРГА:

Ж.СОЛОНГО

(НХОГ-ын Санхүү, аж ахуйн хэлтсийн
Хөрөнгө оруулалтын санхүүжилт
хариуцсан мэргэжилтэн)